

## **1. Цахим Засгийн тухай хууль**

“Мэдээлэл, Харилцаа Холбооны салбарын 2010 он хүртэлх хөгжлийн үзэл баримтлал”-д заасны дагуу Мэдээллийн Технологийн багц хууль боловсруулах ажлын хэсгийг 2002 онд байгуулсан юм. Энэ ажлын хэсгээс “Цахим Засгийн тухай” хуулийн төслийг хэд хэдэн хувилбараар боловсруулсан боловч тухай үед ач холбогдлыг нь ойлгоогүйн улмаас дэмжигдээгүй болно. Хуулийн төслийг анх боловсруулсан үеэс хойш цахим засгийн хөгжил шинэ шатанд гарч, дэлхийн нилээд олон улсад “Цахим Засгийн” хууль батлагдан гарсан байна. Тиймээс тухай үед боловсруулж байсан хуулийн төсөл, үзэл баримтлалыг дахин шинээр боловсруулах, шинэ агуулгаар баяжуулах шаардлага тулгарч байна. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хуулийн үзэл баримтлалыг шинээр боловсрууллаа.

### **“ЦАХИМ ЗАСГИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. “Цахим Засгийн тухай” хуулийн төсөл боловсруулах шаардлага,  
үндэслэл**

Монгол Улсад бүртгэлийн төгөлдөршлийг бий болгох нь цахим засгийн хөгжилтэй салшгүй уялдаатай. Одоогоор “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд “Цахим Засгийн” мастер төлөвлөгөө батлан гаргаж хэрэгжүүлэх зарим арга хэмжээг авч байгаа боловч тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй, өөрөө өөрийгөө зохицуулах зарчмаар хөгжиж явна. Хэдийгээр яам, агентлагууд тус тусдаа мэдээллийн технологийг хөгжүүлэхийг оролдож, цахим засгийн зарим үйлчилгээг уялдаа холбоо муутайхан хэрэгжүүлэхийг оролдож байгаа боловч Төрийн албан хаагчид, удирдах ажилтнуудад Цахим засгийн тухай мэдлэг ойлголт бүрэн сайн төлөвшөөгүй, аливаа зүйлийг албан шахалт, эрх зүйн заалтын дагуу хэрэгжүүлэх хандлага, сэтгэлгээтэй байгаа өнөө үед өөрөө өөрийгөө зохицуулах зарчим огт нийцэхгүй, “Цахим Засгийн” мастер төлөвлөгөөнд заагдсан заалтууд цаасан дээрх хоосон үг болон хувирахаар магадлал үүсэж байна. Тиймээс дэлхийн улсуудын жишгээр цахим засгийн хууль батлан гаргаснаар “Цахим Засгийн” мастер төлөвлөгөөнд заагдсан арга хэмжээг цаг алдалгүй, түргэн шуурхай, зардал багатайгаар хэрэгжүүлж улмаар төсвийн хөрөнгийг ихээр хэмнэх боломж бүрдэх юм.

Цахим Засгийн тухай хууль батлан гаргах эрх зүйн болон практик шаардлагууд дээр дурдсан үндэслэлүүдээс урган гарч байна.

### **1.1. Эрх зүйн шаардлага**

“Цахим Засгийн Мастер төлөвлөгөө”, “Цахим монгол” хөтөлбөр болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, сайн засаглал хөтөлбөр, хууль тогтоомжийг 2010 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд мэдээллийн технологи, цахим засгийн эрх зүйн орчныг нь бүрдүүлэх талаар тодорхой заалтууд туссан юм.

Монгол Улсад “УИХ-ын тухай хууль”, “Засгийн газрын тухай” хууль, “Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн нэгж, Түүний Удирдлагын Тухай” хууль болон холбогдох бусад актуудаар төрийн удирдлагын асуудлыг зохицуулдаг. Гэвч эдгээр хуулиудад цахим засаг, төрийн удирдлага дахь мэдээллийн технологи, түүний хэрэглээтэй холбогдсон харилцааг зохицуулсан заалт огт байхгүй, энэ талаархи заалт бүхий бусад хуулиуд ч батлагдан гараагүй байна. Үүний улмаас цахим засгийн тухай нэгдсэн ойлголт, мэдлэг бүрэлдэн тогтохгүй, хэрэгжиж буй төслүүд уялдаа холбоогүй, хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулсан шинжтэй, цахим засгийн “үр дүнтэй, хэмнэлттэй, нэг цонхны, иргэндээ хандсан” байх зарчим алдагдаж, байгууллага бүрийн тус тусын үйл ажиллагаа болон хувирсан байна.

Тиймээс цахим засгийг хөгжүүлэх талаар төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, цахим засгийн үндсэн зарчмуудыг тодорхойлох, төрийн онлайн үйлчилгээг хөгжүүлэх, нээлттэй засаглалыг хөгжүүлэх, засаглалд иргэдийн оролцох боломжийг бүрдүүлж, засаглалын найдвартай, шуурхай байдлыг хангах, цаасгүй технологи нэвтрүүлэх, төрийн цахим баримт бичиг үүсгэх, боловсруулах, илгээх, дамжуулах, төрийн өгөгдөл мэдээллийг дундаа хамтран ашиглах, цахим баримт бичгийн эрх зүйн байдлыг тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг бий болгох, цахим засгийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн шаардлага бий болоод байна.

### **1.2. Практик шаардлага**

Дэлхий дахины хөгжлийн чиг хандлагатай уялдан манай улсад мэдээлэл, холбооны технологи маш хурдацтай хөгжиж, мэдээллийн технологи, түүний хэрэглээтэй холбогдсон үйл ажиллагаа өдрөөс өдөрт өргөжин тэлж, иргэн,

хуулийн этгээд, төр, засгийн бүх шатны байгууллагыг хамран, тэдний хоорондын мэдээллийн харилцаа улам бүр нарийн төвөгтэй болж, мэдээллийн технологийн талаар бие биенээсээ хамаарах хамаарал нь байнга нэмэгдэн, өндөр өртөгтэй, асар богино хугацаанд өөрчлөгдөн шинэчлэгддэг, мэдлэг оюуны өндөр чадавхи шаардсан техник, технологийн ашиглалтын эцсийн үр дүн нь эрх зүйн зохицуулалтаас шууд хамаардаг цоо шинэ салбар бий боллоо.

Тэр дундаа цахим засгийн G2G, G4B, G4C модулийн харилцааг зохицуулсан тодорхой хууль тогтоомж байхгүй байгаа нь төсвийн зардлыг өсгөх, хүнд суртал, авилгалыг хөгжүүлэх, төрийн удирдлагын бизнес реинжинирингийг боогдуулах, төрийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэхэд саад тотгор учруулах боломжийг бүрдүүлж байна.

Гадаадын улс орнуудын туршлагаас харахад мэдээллийн технологи, цахим засгийн чиглэлээр нилээд нарийвчилсэн хууль, эрх зүйн актуудыг боловсруулан мөрдөж байна. Тухайлбал АНУ, Австри, БНСУ-д “Цахим засгийн хууль”, бусад хөгжингүй улсуудад цахим засгийн зохицуулалт агуулсан олон хуулиуд болон эрх зүйн актуудын батлан гаргаж мөрдсөнөөр цахим засаг хүчтэй хөгжиж байна. Үүний үр дүнд төрийн удирдлагад цаасгүй технологи нэвтэрч, төрийн өгөгдлийг хамтран ашиглах болсноор төрийн үйлчилгээний үр нөлөө өндөрсөж, төсвийн асар их хэмнэлт гарч, иргэдийг чирэгдүүлэх явдал арилжээ.

### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг **Нийтлэг үндэслэл, Цахим засгийг хэрэгжүүлэх үндсэн зарчмууд, Цахим засгийн удирдлага, зохион байгуулалт, Цахим засгийн үйлчилгээ, Цаасгүй технологи, Цахим засгийн төслийн удирдлага, Бусад** гэсэн 7 бүлэгтэй 50-иас доошгүй зүйлтэй боловсруулж болох бөгөөд **нэгдүгээр бүлэгт** цахим засгийн тодорхойлолт, хүрээ, төрийн байгууллагуудын болон албан хаагчдын хүлээх болон гүйцэтгэх үүрэг, **Хоёрдугаар бүлэгт** цахим засгийг хэрэгжүүлэх зарчмууд, **Гуравдугаар бүлэгт** цахим баримт бичгийг үүсгэх, боловсруулах, дамжуулах, хүлээн авах, ашиглах журам, тоон гарын үсэг ашиглах, төрийн өгөгдлийг хамтран ашиглах, мэдлэгийн менежмент, бизнес реинжиниринг, цахим засгийн стандарт, мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ, сүлжээнд ажиллах, зайнаас ажиллах, төрийн албан хаагчдыг хөгжүүлэх тухай

зохицуулалт орох нь зүйтэй. **Дөрөвдүгээр бүлэгт** төрийн үйлчилгээнд сүлжээгээр дамжин хандах, үйлчилгээний хүсэлт, хандалт, өргөдөл, гомдол, хүсэлтийг боловсруулах, адилтгах, таньж зөвшөөрөх, сүлжээгээр дамжуулан хариу өгөх, мэдэгдэх, сүлжээгээр хүргүүлж буй мэдээллийн удирдлага, сүлжээний үйлчилгээний төлбөр, хураамж, сүлжээгээр төлбөр тооцоо хийх зохицуулалтыг оруулна. **Тавдугаар бүлэгт** цаасан тээгч дээрх баримт бичгийг багасгах, цахим хэлбэрээр өгөгдөл солилцох систем байгуулах, шифрлэх, тоон гарын үсгээр баталгаажуулах, цаасгүй технологид шилжих асуудлыг хариуцсан байгууллага, төлөвлөх асуудлыг зохицуулна. **Зургаадугаар бүлэгт** цахим засгийн удаан хугацааны бизнес төлөвлөгөө, төслийн дэмжлэг, урьдчилсан хэлэлцүүлэг, гүйцэтгэлийн үнэлгээ, туршилтын төсөл хэрэгжүүлэх, мэдээллийн систем хөгжүүлэх, нутгийн цахим удирдлага, төр хувийн түншлэлийг ашиглах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зохицуулалтууд орно. **Долоодугаар бүлэгт** төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудад ашиглах программ хангамжийг нэгдсэн журмаар боловсруулах буюу захиалах, түүнийг эзэмших эрхийг төрд олгох, цахим засгийг хөгжүүлэх зардлыг жил бүрийн төвлөрсөн төсөвт тусгах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулах тухай заалтуудыг оруулна.

**Дөрөв. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал**

4.1. Дэлхий нийтийн хэмжээнд мэдээллийн технологид суурилан төрийн удирдлага, үйлчилгээг үр дүнтэй, хэмнэлттэй, иргэндээ хандсан, нэг цонхны болгон хувиргаж байна. Энэ хандлага манай улсын хувьд ч чухал ач холбогдолтой болж, цахим засгийг хөгжүүлэх санхүү, эдийн засаг, зохион байгуулалт, техник технологи, эрх зүйн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага бий боллоо. Энэ утгаар юуны өмнө хуулийн төсөлд заасны дагуу бүтэц, зохион байгуулалт, технологийн өөрчлөлт хийх шаардлагатай болох бөгөөд ингэхдээ төсвөөс нэмэлт зардал гаргалгүйгээр одоогийн байгаа орон тоо, цалингийн фондод багтаан төрийн байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжлийн хүний нөөцийн хүчийг нэгтгэх, хөгжүүлэх, мэргэшсэн байгууллагын үйлчилгээ авах, холбогдох зарим үйлчилгээг хувийн секторт

шилжүүлэх (аутсорсинг), төр хувийн түншлэлийг хөгжүүлэх замаар шийдвэрлүүлэх саналтай байна.

Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын зардал, дотоод сүлжээний урсгал зардал, компьютерийн ашиглалтын зардал болон засвар үйлчилгээ, программ хангамжийн захиалга, шинэчлэлт, өөрчлөлтийн зардал гэх мэт олон зардлыг тэр бүр төсөвт бүрэн тусгаж чаддаггүйгээс компьютерийн сүлжээний хэвийн ажиллагаанд муугаар нөлөөлөх тал гарч байна. Цахим засгийн хөгжлийн нийт урсгал зардлыг төрийн болон төсөвт байгууллагуудын жилийн төсвийн 0.7 хувьтай тэнцэхээр бодож хуулийн төсөлд уг саналыг тусгах нь зүйтэй.

Цахим засгийг хөгжүүлэхтэй холбогдон төрөөс гарах зардлыг тусгайлан боловсруулж, Засгийн газрын стратеги, бодлого, төслийн хүрээнд жич шийдвэрлэж байх нь зүйтэй гэсэн саналтай байна. Үүнтэй хамт нийгэм-эдийн засгийн үр дагаварын тооцоо, саналыг боловсруулж, үр ашгийг нь тооцож байх нь зүйтэй болов уу.

4.2. Хуулийн төсөлд хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой байгууллагад хариуцуулахаар тусгах нь зүйтэй.

4.3. Хуулийг хэрэгжүүлэх явцад зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий байгууллагыг нарийн тодорхойлж өгөх шаардлагатай.